



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 76

Есөнбулаг сум

Хөнгөлөлтэй зээл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 78 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор "Аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын шаардлага хангасан хавсралтад дурдсан төсөлд хөнгөлөлтэй зээл олгосугай.

2. Шалгарсан төсөлд хөнгөлөлтэй зээл олгох гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь холбогдох хууль журмын дагуу хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2018 оны 09 дүгээр сарын 20 ны өдрийн  
7.6 дугаар тогтоолын хавсралт



ХӨНГӨЛӨЛТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ

№	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Төслийн нэр	Үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл тоо	Олгох зээлийн хэмжээ /сая төг/
1	Ц.Мөнхбаатар	Үхэр сүрэг	50 толгой мах сүүний чиглэлийн сайн үүлдрийн үхэр худалдан авч жилд 228432 л сүү, 2056 кг мах борлуулна. 250 кг амьдын жин бүхий махны үхэр өсгөнө. 8 хүнийг ажлын байраар хангана.	20,0

----oOo---